



**ГОЛ, НУУРЫН МӨС ЦӨМРӨХ, ШАР УСНЫ ҮЕРИЙН АЮУЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

1.1 Цаг уурын байгууллагын боловсруулсан мэдээгээр 2023-2024 оны өвөл нийт нутгийн 60 орчим хувьд дунджаас ахиу хур тунадас орж, 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нутгийн 80 гаруй хувьд цасан бүрхүүл тогтож, Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дарьгангын тал нутгаар 20 см-ээс их, хунгарлаж шуурсан газартаа 60 см хүртэл зузаан цастай байна.

1.2 Цас ихтэй уулархаг нутаг, томоохон гол, мөрөн, нуурын орчим шар усны үерийн улмаас иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирох, мал амьтан өртөж хорогдох, хүн малын халдварт өвчин дэгдэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулна.

2.2. Нэгдсэн арга хэмжээг аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны иргэд, малчид, олон нийтийг хамруулан зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Бүс, орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлын удирдамжийг боловсруулан, аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна.

3.2. Ус цаг уур, орчин шинжилгээний газраас цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, шар усны үер, мөс цөмрөхөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагад "Багц мессеж", бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй хүргэнэ.

3.3. Үерийн хамгаалалт, ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулж, далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хариуцагч байгууллагаар хийлгэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавина.

3.4. Төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр болон баталгаагүй зам, гүүр гарамгүй газраар зорчихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээ тогтмол хүргэх, эрсдэл бүхий газруудад анхааруулах самбар байршуулна.

3.5. Иргэдийг үерийн эрсдэл бүхий газарт бууж суурьшихгүй байх, үерийн хамгаалалтын суваг, шуудуу татах, сурталчилгаа мэдээлэл түгээх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авна.

3.6. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг орон нутгийн Онцгой комисс, холбогдох мэргэжлийн байгууллага, малчин иргэдтэй хамтран устгах, халдваргүйжүүлэлт хийлгэж, хяналт тавина.

3.7. Мал, амьтны гоц халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг цахимаар иргэд олон нийтэд хүргэнэ.

3.8. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Аймгийн нэр	Шар усны үерт өртөх аюултай өрхийн тоо	Мэдэгдэл, сэрэмжлүүлэг хүргэсэн байдал	Гол, нуурын усанд осолдсон дуудлага			
			Тоо	Эрсдсэн хүн	Тээврийн хэрэгсэл	Аварсан хүн

Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний зардал, үр дүнг тайлагнах

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газар удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.

4.3. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газарт uugankhUU@nema.gov.mn цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.4. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний үр дүнг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж, Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ.

---o0---